

ХҮҮХДИЙН ХӨГЖИЛД ОРУУЛАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

SOME PROBLEMS OF INVESTING IN CHILDREN'S DEVELOPMENT

Ц.Өнөболд

*Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Нийгмийн ухааны тэнхимийн багш, цагдаагийн ахлах дэслэгч*

Хураангуй: Хүний хөгжлийн хамгийн эрчимтэй, чухал үе болох бага насны хөгжил, боловсролыг дэмжих нь насан туршийн ухаалаг хөрөнгө оруулалт болохыг олон судалгаа нотолж байна. Бага насны хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, халамж асаргаа, хамгаалал, хөгжил боловсролыг нэгдмэл хандлага, арга зүйгээр дэмжиж ажиллах нь Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх зорилтуудын нэг болж байна. Тогтвортой хөгжлийн зорилтууд болон Монгол Улсын үндэсний хөгжлийн үзэл баримтлал 2030-д зургаа хүртэлх насны хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, халамж, хамгаалал, хөгжил боловсролын зорилтуудыг илрүүлэх үзүүлэлтийг нарийвчлан тусгасан. “Хүн болгон адилгүй хүлэг болгон жороогүй гэдэг ардын зүйр цэцэн үгэнд хүүхэд бүрийн зан төлөв, сэтгэлзүйн байдлаасаа хамаараад сурах арга барил, чадвар өөр гэдгийг илэрхийлдэг. Эдгээр чадвар хүүхдийн бага насанд нь бүрэлдэн бий болж, насан туршдаа хэрэглэх олон чадавхийг бий болгодог байна. Үүнийг Эдийн засгийн салбарын Нобелийн шагналтан Жеймс Хекман “Хүний капиталын онолыг ашиглан ядуу амьдралтай гэр бүлүүдэд учирч буй тэгш бус байдал нь хүний капиталын хөгжлийн түвшин доогуур ялангуяа танин мэдэхүйн чадварын тэгш бус байдлаас үүдэлтэй гэдгийг нотолсон. НҮБ-гийн сангийн гүйцэтгэх захирал “ Улс орны хөгжил цэцэглэлтийг нэмэгдүүлэх эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг дэмжих, тэгш боломжийг өргөжүүлэх нэн ядуурлыг арилгах хамгийн чухал арга зам бол бага насны хүүхдэд хөрөнгө оруулах юм гэжээ. Бидний балчир насандаа туулж өнгөрүүлсэн туршлага тархины хөгжилд нөлөөлж, насанд хүрсэн хойноо ямар хүн болоход нөлөөлдөг.

Тиймээс судалгааны ажилдаа хүүхдийн хөгжилд оруулах хөрөнгө оруулалтын онолын агуулгыг судлан, эцэг эхчүүдийн хүүхдийнхээ

хөгжилд оруулж буй хөрөнгө оруулалтын талаарх ойлголт, ямар бэрхшээл байгааг тодруулан цаашид шийдвэрлэх арга замыг хамтран зөвлөлдөж, түгээн дэлгэрүүлэх зорилгоор энэхүү илтгэлийг бичлээ. Илтгэл нь оршил \түлхүүр үг, судалгааны зорилго, зорилт, сэдвийн үндэслэл, судалгааны арга зүй, судалгааны ач холбогдол, шинэлэг тал, дэвшүүлж буй таамаглал, \ Үндсэн хэсэг \ Онолын ойлголт, судалгааны хэсэг, туршиж хэрэгжүүлсэн байдал, судалгааны үр дүн, \ Төгсгөл хэсэг \ Судалгааны ерөнхий дүгнэлт, ном зүй \ гэсэн үндсэн 3 хэсгээс бүрдэнэ.

Summary: Numerous studies show that supporting early childhood development and education, the most intensive and critical period of human development, is a wise lifelong investment. Supporting the health, nutrition, care, protection, development and education of young children with a unified approach and methodology is becoming one of Mongolia's priority development goals. The Sustainable Development Goals and Mongolia's National Development Concept 2030 include detailed indicators for detecting health, nutrition, care, protection, and development goals for children under the age of six. "Every person is not created equal. The proverb means that every child has different learning methods and abilities depending on their behavior and psychological state. These abilities are formed at a young age and create many abilities that can be used throughout life. James Heckman, winner of the Nobel Prize in Economics, used the theory of human capital to prove that inequality in poor families is caused by low levels of human capital development, especially inequality in cognitive abilities.

The Executive Director of the United Nations Fund said that investing in young children is the most important way to eradicate extreme poverty and promote inclusive economic growth that will increase the country's prosperity and expand equal opportunities. The experiences we go through in childhood affect the development of the brain and shape the person we become as an adult.

ҮНДСЭН ХЭСЭГ

Монголын ард түмний харилцааны үнэт зүйлсийн нэг нь “Миний хүүхэд надаас илүү сайхан амьдрах ёстой” хэмээх философи төдийгүй өрх гэр бүл, ээж аав бүр үр хүүхдийнхээ төлөө бүхнийг зориулах нандин уламжлалтай. Орчин үеийн нийгэм, гэр бүлийн амьдралын хэв шинж энэхүү нандин уламжлал алдагдаж байна. Ээж, аав нар ажилтай, завгүй гэдэгт өөрийгөө итгүүлж улмаар үр хүүхдэдээ цаг гаргаж хамтдаа байх нь багасаж, хүүхдээ үл хайхрах, дэлгэцийн хамааралтай болох, хараа

хяналтгүй орхих, эсвэл ажил, хэн нэгнээс шалтгаалсан уур бухимдлаа хүүхдэдээ гаргах, тэднийг хараан загнах, зодох зэргээр зүй бусаар харилцах нь буурахгүй байна. Бага насны хүүхэдтэй холбоотой санаатай болон санамсаргүй гэмт хэргийн тоо өдөр тутам нэмэгдсээр. Нөгөө талаас өрхийн орлогын түвшин доогуур, ядуу зүдүү амьдралтай байх нь гэр бүлд бага насны хүүхдийн хөгжлийг зохистой хэлбэрээр дэмжиж чадахгүй байх бас нэгэн шалтгаан болж байна. Учир нь 3 настай хүүхдийн тархи насанд хүрсэн хүний тархинаас хоёр дахин илүү идэвхтэй, хурдтай, уян хатан байдаг. Гэтэл тархины хурд буюу уян хатан байдал нь 7 насны орчимд 50 хувиар буурдаг гэдгийг тархи судлалын эрдэмтэд нотолж байна ¹

Тогтвортой хөгжлийн зорилт 4.2. 2030 он гэхэд бүх охид, хөвгүүд бага насны хүүхдийн хөгжил, асаргааны чанартай үйлчилгээ, сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж, улмаар бага боловсрол эзэмшихэд бэлтгэгдсэн байна. Энэхүү зорилт нь бага насны хүүхдэд оруулах хөрөнгө оруулалт нийгмийн тогтвортой хөгжлийн тулгуур гэдгийг илэрхийлж байна.

Монгол улсын үндсэн хуулийн 17.2 “Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн”² гэж заасан нь эцэг эхийн хүлээсэн үүргийг чухалчилж, ухамсарлуулах үндэс нь болж өгсөн.

Хүүхдийн хөгжилд оруулж буй хөрөнгө оруулалтын тухай

Дэлхийн өнцөгт булан бүрт бизнесийн салбарт ажиллаж буй биенесменүүд өөртөө хэрэгтэй, ирээдүйд ашиг олж чадах салбарт хөрөнгө оруулж ашгаа тооцоолдог. Тэгвэл хүн төрөлхтөний хамгийн үнэ цэнэтэй зүйл юу вэ? Энэхүү асуултанд олон хариулт ирэх боловч, эцсийн дүнд энэ бол бидний хойчийг залгамжлах үр хүүхэд гэдэгтэй хүн бүр санал нийлэх биз. Өнөөдрийн байдлаар монголд 1 сая гаруй хүүхэд өсч, хүмүүжиж буй боловч, тэдгээр хүүхдүүдийн хэдэн хувь өөрийн амьдралыг хэний ч гар харахгүй цогцлоож чадах чадвартай болж байгааг хэн ч таашгүй. Улс орон хүчирхэг болохын тулд хүн амын өсөлтөө анхаарах хэрэгтэй. Хүнээ өсгөхийн тулд хүүхдийнхээ ирээдүйд оюуны болоод материаллаг хөрөнгө оруулалтыг хийснээр бид өндөр хөгжилтэй орнуудтай мөр зэрэгцэн алхах болно. Эдийн засгийн салбарын Нобелийн шагналтан Жеймс Хекман “Бага

¹ Нилсон, 2000

² Монгол улсын Үндсэн хууль.,УБ.,1992 он; 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалт, <https://legalinfo.mn/mn/detail/367> ;

насны хүүхдийн хөгжилд оруулсан хөрөнгө нь эдийн засагт хамгийн өндөр өгөөжтэйг тодорхойлсон. (Хүний хөгжлийн хөрөнгө оруулалтын өгөөжийн муруй

Зураг 1. Хөрөнгө оруулалтын өгөөж



Хүний тархины хөгжлийн хамгийн эрчимтэй үе болох зургаа хүртэлх насанд хоол тэжээл, хайр халамж, энэрэнгүй сэтгэл дутагдвал хожим нь засаж залруулах боломж бага, бас маш өндөр зардалтай аж. Ядуу төрсөн эрүүл ахуйн шаардлага хангаагүй нөхцөлд амьдардаг сэтгэцийн өдөөлт хүмүүжил багатай хүүхдүүд баян өссөн хүүхдүүдээс оюун санааны хувьд хоцрогдолтой өсөх магадлал өндөр байдаг. Эдгээр хүүхдүүд хичээлдээ тааруухан, ур чадвар муутай, хамгийн бага цалин авдаг. Хүүхдийн амьдралын эхний хэдэн жил онцгой чухал байдаг. Хүүхдийн бага нас нь хүний эрүүл мэндэд чухал ач холбогдолтой. Хүний капиталын хуримтлал нь амьдралын мөчлөгийн динамик үйл явц бөгөөд ур чадварыг бий болгодог байна. Дараах 3 санаа нь бага насны хүүхдийг ойлгох түлхүүр болж байна.

1. Насанд хүрэгчдийн чадавхийг төлөвшүүлэхэд гэр бүлийн амьдрал, хүүхдийн бага нас чухал үүрэг гүйцэтгэдэг. Ж.Хейкман чадвар нь төрөх үед тогтдоггүй, харин эцэг эхийн хүүхэддээ оруулсан хөрөнгө оруулалтаас шалтгаалдаг ба сул талыг нь зөв хэмжих нь эцэг эхийн хүмүүжил, тууштай байдал, хяналт чухал үүрэгтэй гэж үзээ.

2. Олон чадвар нь хувь хүний нийгэмд ажиллах чадварыг бүрдүүлдэг. Үндсэн чадварууд нь танин мэдэхүй болон танин мэдэхүй бус аль аль нь амьдралын олон салбарт амжилтад хүрэхэд тусалдаг.

3. Чадвар бүрэлдэх нь синергитик шинж чанартай байдаг. Учир нь нэг чадвар нь нөгөө чадвараа сайжруулдаг. Өөрөөр хэлбэл чадвар

чадваруудыг бий болгодог. Танин мэдэхүйн болон танин мэдэхүйн бус чадварууд динамикаар харилцан үйлчилж, хөгжлийн хувьслыг бий болгодог. Эцэг эхчүүд тууштай байх, хамтран ажиллах, урам зориг өгөх цагийг илүүд үзэх нь хүүхдийнхээ капитал буюу чадварт хөрөнгө оруулж байгааг илэрхийлдэг байна. Тэрээр зургаа хүртэлх насны хүүхдийн хөгжилд оруулсан 1 доллар тутмын өгөөж нь 12.90 доллар болохыг тооцоод, “Энэ хөрөнгө оруулалт нь зөвхөн боловсрол эзэмшиж буй хүмүүсээс гадна улс орны эдийн засгийн хөгжилд өндөр ашигтай” учраас хөгжлийн стратегийн амин чухал хэсэг гэж дүгнэжээ.

4. Ж.Хекман хэлэхдээ, "Төрийн албан тушаалтнууд хүүхдийн амьдралын үе шат бүр нь нөгөөгөөсөө хамааралгүй, өмнөх болон ирээдүйд хүлээж буй зүйлтэй холбоогүй юм шиг, амьдралынхаа туршид даршилсан газар амьдарч байгаа мэт хүүхдүүдэд зориулсан хөтөлбөр боловсруулдаг. Бодлого боловсруулагчид хүүхэд, залуучуудад тогтвортой, үр ашигтай хөрөнгө оруулалт хийснээр өөрийгөө нөхөж чадна гэдгийг ухамсарлаж эхлэх цаг нь болсон." Урьдчилан сэргийлэх боломжтой байсан зүйлийг засч залруулахын тулд хожим мөнгө төлөхөөс илүүтэйгээр хүүхдийн чадавхийг нэмэгдүүлэх боломжтой Тиймээс бид амьдралынхаа эхний жилүүдэд илүү цогц арга барил буюу "эхнээсээ тэгш байдал"-аас эхлэх ёстой.

“НҮБ-ын Хүүхдийн сангийн Гүйцэтгэх захирал Энтони Лэйк хэлэхдээ, "Биологи бол хувь тавилан биш бөгөөд хүүхдүүдийн амьдралын эхний өдрүүд, он жилүүд нь тэдний ирээдүйг бүрдүүлж, тодорхойлдог гэдгийг шинжлэх ухаан бидэнд харуулж байна. "Бид энэ шинжлэх ухааныг түгшүүрийн хонх болгон хувиргах хэрэгтэй - учир нь сая сая хүүхдийн хөгжил яаралтай эрсдэлд орж байна. Яг одоо бага, дунд орлоготой орнуудын хүүхдүүдийн 43 хувь нь танин мэдэхүйн чадавхдаа хүрэхгүй байх эрсдэлтэй байна. Аль ч улс хамгийн залуу иргэдийнхээ тархины чадавхийн бараг тал хувийг, тэр дундаа бага, дунд орлоготой орнуудыг алдах эрсдэлтэй байж чадахгүй.¹

АНУ-ын сэтгэл зүйч, эдийн засагч, социологич, хүн ам зүйч, улс төр судлаач, нийгмийн ажилтан, эмнэлгийн эмч нар хүүхдийн хөгжилд нөлөөлж буй үйл явцын талаар дүгнэн, хүүхдэд төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг хэрхэн ухаалгаар нэмэгдүүлэх, тэдний сайн сайхан байдал болон хойч үеийнхээ бүтээмжийг дэмжих нь чухал гэж үзжээ.

¹ НҮБ-ын Хүүхдийн сангийн Гүйцэтгэх захирал Энтони Лэйк

Хүүхдэд хийгдэж буй хөрөнгө оруулалтыг судалж, хүүхэд насанд хүрсэн хүний хувьд ажил, гэр бүл, нийгэмд амжилт гаргахад шаардлагатай ур чадваруудыг хөгжүүлэхэд хэрхэн нөлөөлж байгааг хэлэлцэн, ядуурал, тэгш бус байдлын мөчлөгийг эвдэх хүүхдэд хөрөнгө оруулалт хийхээс илүү сайн арга байхгүй гээд 5 үндсэн чиглэлд хөрөнгө оруулалтыг өргөжүүлэхийг санал болгосон байна.

1. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг сайжруулах хөтөлбөр;
2. Хамгийн эмзэг бүлгийн хүүхдүүдэд чиглэсэн бага насны хүүхдийн оролцоо;
3. Хүүхэд асрах, сургуулийн өмнөх боловсролын чанарыг дээшлүүлэх арга хэмжээ;
4. Хичээлийн дараах болон зөвлөх хөтөлбөрүүд;
5. Бага орлоготой гэр бүлийн өндөр чадвартай залуучуудын коллежид хамрагдах түвшинг дээшлүүлэх хөтөлбөрүүд.¹

Судлаач Ж.Хейкманаас гадна Вашингтоны Lancet сэтгүүлийн судалгааны тайланд

“Бага насны хүүхдийн хөгжилд хөрөнгө оруулах нь илүү олон хүүхэд, олон нийтийг цэцэглэн хөгжихөд нь чухал ач холбогдолтой болохыг тогтоожээ. Эрүүл мэнд, хоол тэжээл, анхаарал халамж тавих, аюулгүй байдал, аюулгүй байдлыг хангах, эрт сургах зэрэгт чиглэсэн бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих арга хэмжээнүүд нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, Дэлхийн Банк, НҮБ-ын Хүүхдийн сан зэрэг байгууллагууд энэхүү цуврал арга хэмжээнд хувь нэмрээ оруулж, заавар өгсөн. Бага насны хүүхдийн хөгжилд дэлхий нийтийн үүрэг амлалтыг нэмэгдүүлэхийн чухлыг онцолж байна. Идэвхгүй байдлын үр дагавар нь зөвхөн одоо төдийгүй ирээдүй хойч үедээ нөлөөлдөг. Хүүхдийн тархи эхний 2-3 жилд амьдралын бусад үетэй харьцуулахад илүү хурдан хөгждөг. Бага насны хүүхдүүд хоол тэжээл, өдөөлт, хамгаалалтгүй байх үед хор хөнөөлтэй үр


¹ Sheldon Danziger, Russell Sage Foundation Previously, University of Michigan Ph.D. Economics,

дагавар нь гэр бүл, нийгэмд урт хугацааны хор хөнөөл учруулж болзошгүй юм. ¹


СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Эцэг эх бүр хүүхэддээ хөрөнгө оруулалт хийж чадаж байна уу? Хүүхдийнхээ хөгжилд оруулж буй хөрөнгө оруулалтад ямар бэрхшээл тулгарч байна вэ? Хөрөнгө оруулалт гэдгийг эцэг эхчүүд юу гэж ойлгодог вэ? гэсэн ерөнхий агуулгыг тодруулах зорилгоор Улаанбаатар хотын БЗД, Хан-уул дүүргийн 151 эцэг эхчүүдээс асуулгын аргаар судалгаа авч боловсрууллаа. Судалгаанд 91 эмэгтэй, 60 эрэгтэй хамрагдлаа.

1. Хүйсийн харьцаа



2. Нас





Оролцогчдын

хүйсийн харьцааг харвал эмэгтэйчүүд хүүхдийнхээ ирээдүйд илүү анхаардаг болох нь харагдаж байна. Насны үечлэлээр харвал 36-аас дээш насныхан судалгаанд идэвхитэй хамрагджээ.

3. Оролцогчдын ажилладаг байгууллага


4. Та хүүхэддээ зав гаргаж чадаж байна уу?



¹ Профессор Линда М.Ричтер, ДСТ-NRF-ийн Хүний хөгжлийн шилдэг төв, Витватерсрандын их сургууль, Йоханнесбург, Өмнөд Африк.

Судалгаанд оролцогчдын 36-38 хувь төр болон хувийн хэвшилд ажилладаг ба 56 хувь нь хүүхэддээ зарим үед л зав гаргаж чаддаг гэж хариулжээ. Үүнээс харахад эцэг эхчүүд хүүхэддээ гаргах цаг зав хомс байгааг харуулж байна.

5.Та хүүхэддээ хэзээ зав гаргах боломжтой байдаг вэ? Гэсэн асуултад



- Амарсан үедээ
- Зориуд цаг гаргадаг
- Зав олддоггүй
-

Оролцогчдын 70,5 хувь нь амарсан үедээ л хүүхэддээ зав гаргах боломжтой гэж хариулнаас харахад ажлын цагаа өөрсдөө гаргадаг хувийн хэвшилд ажиллаж


байгаа эцэг эхчүүд хүүхэддээ гаргах цаг зав тун ховор байх магадлалтай. Зориуд цаг гаргаж буй 27 хувийг эзэлж буй эцэг эхчүүдэд талархмаар. Улс орныхоо ирээдүйд үнэтэй хөрөнгө оруулалт хийж байгаа хэрэг юм.

6.Та хүүхдийнхээ хөгжилд оруулж буй хөрөнгө оруулалтыг юу гэж ойлгодог вэ гэсэн асуултыг эрэмбээр жагсаавал

1. Боловсрол
2. Хүүхэддээ хөрөнгө оруулах ёстой
3. Ирээдүйн баталгаа
4. Гэр бүлийн хүмүүжил, цаг баримтлах хоёр хамгийн том хүмүүжил
5. Оюунд нь хөрөнгө оруулах
6. Сонирхлыг сонсож, сурч боловсрох хэрэгцээг нь хангах
7. Сэтгэл оюун санааны боловсрол
8. Хүмүүжил, хүүхэддээ өгч болох бүх зүйл
9. Чин сэтгэлийн харилцаа, зөв хайрлах, ирээдүйдээ итгэлтэй болгох, сургааль
10. Байх ёстой зүйл
11. Эрх чөлөө
12. Сургалтад хамруулах
13. Хэдэн төгрөг өгөхөөс шалтгаална-?


Дээрх хариултуудаас харахад эцэг эхчүүд хөрөнгө оруулалт гэдгийг боловсрол, зөв хайрлах, гэр бүлийн хүмүүжил, цаг баримтлах, чин сэтгэлийн харилцаа гэж ойлгож байгаа эцэг эхчүүд хүүхэддээ цаг зав гарган хүнийг хүн болгоход илүү анхаардаг гэж үзэж байна. Түүнчлэн хүүхэддээ өгч болох бүх зүйл гэсэн хариултад оюуны болон материаллаг хөрөнгө оруулалтыг хоёуланг ойлгож болно. Хүн төрөлхтөн хөгжлийн дээд шатанд хүрсэн үед ч хамгийн үнэ цэнэтэй баялаг бол үр хүүхэд, тэдний хэн болох нь хамгийн чухал асуудал байсаар байх болно.

6.Та хүүхэддээ өгч буй хамгийн чухал хөрөнгө оруулалтыг юу гэж боддог вэ?



Дээрхи асуултад эцэг эхчүүдийн 25 хувь аюулгүй орчин, 29 хувь нь эрүүл, мэнд, боловсрол, 30 хувь хүмүүжил, төлөвшил, 6,8 хувь нь эд хөрөнгө гэж хариулснаас харахад орчин үеийн эцэг эхчүүд эд хөрөнгийг хүүхэдд өгөх хөрөнгө оруулалт гэж үзэхгүй байгаа нь сайшаалтай.

7.Та хүүхэддээ хөрөнгө оруулж чадаж байна уу? 8.Та ямар хөрөнгө оруулж байна вэ?




Дээрхи асуултын хариултаас харахад эцэг эхчүүдийн 65.9 хувь нь хүүхэддээ хөрөнгө оруулалт хийж чадаж байна гэж үзсэн бол 29.5 хувь чадахгүй байна гэж хариулсан байна. 29.5 хувийг эзэлж буй хариултын цаана нийгмийн олон асуудлуудын дунд хүүхэддээ цаг, мөнгө гаргаж чадахгүй байгаа эцэг эхчүүдийн төлөөллүүд юм. Эцэг эхийн төлөөллийн 63.6 хувь нь оюуны хөрөнгө оруулалт, 25 хувь нь материаллаг хөрөнгө оруулалт өгч байна.

9. Та хүүхдийнхээ хөгжилд хөрөнгө оруулахад ямар бэрхшээл тулгарч байна вэ? гэсэн асуултад



Эдгээр хариултууд санхүүгийн хязгаарлагдмал байдал, цаг наргүй ажлын ачаалал, нийгмийн аюултай нөхцөл, үе тэнгийхэний сөрөг дадлаас болж, хүүхдийн ирээдүйд хөрөнгө оруулалт хийгдэхгүй байгааг илэрхийлж байна. Эцэг эхчүүд бид санхүүдээ баригдаад наад захын материаллаг хэрэгцээг хангаад, хүмүүжил төлөвшилийг нь орхигдуулаад байх хандлага ажиглагддаг.

10. Тулгарч буй бэрхшээлийг шийдэх арга замуудаас нэрлэнэ үү? гэсэн асуултад



Эдгээр хариултууд эцэг эхчүүд хүүхдийнхээ хөгжилд өөрийн боломжоороо хөрөнгө оруулах аргаа шийдэж буй боловч, оролцогчдын 18 хувь нь мэдэхгүй, мөн хариулаагүй байгаагаас харахад мухардалд орсон байгаа нь харагдаж байна. Дээр шараар бичигдсэн хэсгүүд бол хөрөнгө оруулалтын чухал арга замууд гэж дүгнэж байна. Өөрөө хүүхдийнхээ хөгжилд хөрөнгө оруулж чадаж байгаа ч хүмүүжилгүй, хайхрамжгүй хүүхдүүдээс болж сөрөг үр дагавар бий болж байгаа нь тэдний хариултаас харагдаж байна.

Судалгааны үр дүн

➤ Эцэг эх болгон хүүхдийнхээ хөгжилд хөрөнгө оруулах хэрэгцээ их байгаа хэдий ч хэрэгцээг хангах санхүү болоод цаг наргүй ажлын ачаалал, үл ойлголцлоос болоод бэрхшээл тулгардаг байна.

➤ Судалгаанд оролцогчдын ихэнхи хувь хүүхдийнхээ оюуны боловсролд хөрөнгө оруулалтад илүү анхаарч, цаг үеийн шаардлагыг бүрэн ойлгож байгаа ч, зөвхөн боловсролд нь анхаараад сэтгэлийн боловсрол, хүмүүжлийг нь орхигдуулж байгаа нь ажиглагдлаа.

Хүүхдийнхээ хөгжилд хэрхэн хөрөнгө оруулалт хийх вэ?

Хүүхдийн эрхийн конвенцед нэгдэн орсноор төр засгийн зүгээс хойч үедээ анхаарах, тэдэнд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн. Хорвоод төрүүлсэн үрээ хүний дайтай өсгөж, хүмүүжүүлэх нь эцэг эх бүрийн туйлын хүсэл байдаг. Бид судалгааны үр дүнд үндэслэн хүүхдийнхээ хөгжилд хэрхэн хөрөнгө оруулах талаар ямар арга зам, боломж байгааг эрэлхийлэв. Монголын нийгэмд амьдарч буй гэр бүлийн амьдралын түвшин харилцан адилгүй боловч, эцэг эхчүүд юуны өмнө дараах чиглэлд анхаарлаа хандуулж, хөрөнгө оруулалт хийснээр өөрийнхөө төдийгүй хүүхдийнхээ ирээдүйд үнэтэй хувь нэмэр оруулах болно. Үүнд:

Эрүүл мэнд	• "Эрүүл биед саруул ухаан оршино" гэсэн үгийн адилаар хүүхдээ эрүүл чийрэг өсгөнө гэдэг тэдний ирээдүйд оруулж буй хамгийн том хөрөнгө оруулалт юм.
Боловсрол	• Хүүхдийг чанартай сургууль, цэцэрлэгт явуулж чанартай боловсрол эзэмшүүлснээр тэдний амьдралаа авч явах чадварыг дээшлүүлнэ. сайн багштай байлгах, шийдэх их дээд сургуульд суралцуулах зэргээр үр хүүхдийнхээ боловсролд оруулсан хөрөнгө оруулалт тань насан туршид үр өгөөжтэй байх болно.
Хүмүүжил, орчин	• Биеэ даасан, өөртөө итгэлтэй, сайн хүн болон төлөвшихөд олон хүчин зүйлс нөлөөлдөг. Хүүхдийн хүмүүжилд доголдол илэрвэл нэн тэргүүнд анхаарах, хүүхэд сэтгэл зүйн хямралд өртвөл түүнийг олж тогтоох, аюулгүй орчинд өсөх, ярилцах гэх мэтээр хүүхдэдээ үргэлж анхаарал халамж тавьж байх нь чухал.
Хоол	• Хүүхдэд чанартай хоол хүнсээр ханган, өсч торних нь хүүхдийн уураг тархины хөгжил сэтгэл санааны төлөвшилд үнэтэй үүрэг гүйцэтгэдэг. Эцэг эхчүүд гэртээ эерэг харилцаатай байх нь маш чухал нөлөөтэй.
Хөрөнгө	• Оюуны болоод материал хөрөнгө үр хүүхдэдээ өвлүүлэн үлдэх нь тэдний ирээдүйн амьдралд, түүнчлэн үр хүүхдэдээ өвлүүлэн үлдэх сайн жишиг болж үлддэг.

1. **Эрүүл мэнд**-Хүний амьдралын эхний 1000 хоногт нь эрүүл мэндийн суурь тавигдаж, бие эрхтэн хөгжин дархлаажиж, оюун хөгжлийн эх суурь тавигдаж, бодисын солилцооны хэтийн төлөв тодорхойлогддог тул эцэг эхчүүд ураг эхийн хэвлийд бүрэлдэн бий болсон мөчөөс эхлэн 2 нас хүртэлх хугацаанд хүүхдийг хамруулах ёстой вакцин, авах ёстой аминдэм, асаргаа сувилгааны талаар маш сайн мэдээлэлтэй байх нь эрүүл мэндийн чухал хөрөнгө оруулалт болно.

2. **Боловсрол**- Тархины жингийн 87% нь (энэ нь 1100 грамм орчим) гурав хүртэлх насанд бүрддэг.¹ Тархины хөгжлийн үндсэн жор нь “өдөөлт ба хариу үйлдэл” байдаг байна. Энэ нь хүүхэд өөрийн шулганаа, нүүрний хувирал, дохио зангаагаараа насанд хүрэгчдийн анхаарлыг өөртөө хандуулж чаддаг ба насанд хүрэгчид түүний хариуд уян зөөлнөөр дуудах, инээмсэглэх, хүссэн үйлдлийг нь хийх өгөх явдал юм. Эцэг эхчүүд янз бүрийн тоглоомын аргаар хүүхдийнхээ юу бодож байгааг мэдэж авах. Жишээ нь Жо-Харригийн сэтгэлийн цонх арга²

3. **Хүмүүжил, орчин** – Эрүүл аюулгүй нийгэмд хүүхдээ өсгөхийн тулд эцэг эхчүүд хараа, хяналтаа өндөржүүлж, шаардлагатай тохиолдолд сургалтад хамрагдаж, мэдээлэл авч байх ёстой. Эцэг эхчүүд бол хүүхдийнхээ толь байдаг. Ялангуяа хүүхэд аавынхаа хэлсэн үг сургааль, үйлдлийг хамгийн сайн тогтоодог гэдгийг эрдэмтэд судалгаагаар тогтоосон тул гэр бүл дэх аавын үүргийг өндөржүүлж, хүүхдийнхээ насны онцлог, зан чанарын талаар мэдлэг мэдээлэл сайтай байх нь аавуудын гэр бүлдээ оруулж буй хөрөнгө оруулалт юм. Бага боловсролын түвшинд суралцаж байгаа хүүхдүүдийн эцгийн боловсрол, ажил эрхлэлт, өрхийн орлого нь анхаарал, сэтгэхүйн хөгжилд нөлөөлсөн.³

4. **Хоол тэжээл**- Хоногт хэрэглэвэл зохих нэр төрлийн хүнсийг насандаа тохирсон давтамж, хэмжээгээр хэрэглэж буй хүүхдийг “Зохистой байдлаар хооллож буй хүүхэд” хэмээн үнэлэгддэг байна. Манай улсын 6-23 сартай хүүхдийн 43.8 хувь зохистой байдлаар хооллож байгааг судлаачид илрүүлсэн.⁴ Зохистой байдлаар хооллож буй хүүхдийн үзүүлэлт хот хөдөөгөөр, бүс нутгаар, өрхийн аж байдлын түвшнээр ялгаатай, тэгш бус байдал бий болсоор байна. Судлаач Ж.Хейкман хүүхдийн хөгжилд бага

¹ Декабан, 1978

² Чадамжид суурилсан сургалтын гарын авлага.,УБ.2013

³ Боловсролын хөгжил, судалгаа арга зүй.,УБ 2018

⁴ Бага насны хүүхдийн цогц хөгжил., 2020

насанд нь илүү анхаарвал эдийн засгийн үр өгөөж, хүүхдийн ур чадварын үзүүлэлтэд эерэгээр нөлөөлдөгийг баталсан эрдэмтэн юм.

5. Хөрөнгө- Оюуны болоод материаллаг хөрөнгө, сэтгэлийн боловсрол болох хүмүүжил төлөвшлийг бага насанд нь зөв чиглүүлж чадвал, үнэлж баршгүй үнэт хөрөнгө бий болно. Өнөөгийн нийгэмд бид хүүхдийнхээ оюунд хөрөнгө оруулж байгаа гэх боловч, сэтгэлийн боловсрол, хүмүүжлийг орхигдуулсны улмаас ялангуяа өсвөр насны хүүхдийн санаанаас гарамгүй гэмт хэргүүд нийгэмд бий болсоор байна.

Энэ бүхний дүнд эцэг эхчүүд бид хүүхдийнхээ хөгжилд хөрөнгө оруулахын тулд өөрсдөө эхлээд гэр бүлийн боловсролтой, эцэг эх байх ямар үнэ цэнэтэй вэ гэдгийг ухаарч ойлгох шаардлагатай байгаа нь нийгэмд гарч буй хүүхдийн эрх зөрчигдсөн, хохирсон олон жишээг бид бэлхнээ харж байна.

ДҮГНЭЛТ

Ирээдүйд нөөц бий болгох хүлээлтэйгээр өнөөгийн нөөцийг хуваариалан ашиглах үйл ажиллагаа бол хөрөнгө оруулалт. Хүн болж төрсний утга учрыг ойлгох гэж өөрт байгаа боломжоо үр хүүхдийнхээ төлөө хэрэгтэй цагт нь ашиглаж чадах ухаан бол эцэг эхийн тэдэнд өгч буй үнэт хөрөнгө юм. Бидний судалгаагаар дэвшүүлсэн:

Таамаглал 1 “Хүүхдийн хөгжилд оруулах хөрөнгө оруулалтыг онолын үүднээс судлах нь түүн дэх бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох боломжтой” гэсэн таамаглал Ж.Хейкийн “Хүний капиталын онолыг ашиглан ядуу амьдралтай гэр бүлүүдэд учирч буй тэгш бус байдал нь хүний капиталын хөгжлийн түвшин доогуур ялангуяа танин мэдэхүйн чадварын тэгш бус байдлаас үүдэлтэй гэсэн онолын агуулгаар тодорхойлогдож байна. Нийгэмд тэгш бус байдлыг багасгахын тулд төрөөс бага насны хүүхэд рүү чиглэсэн эрүүл мэнд боловсрол, хүмүүжлийн цогц бодлогыг хэрэгжүүлж, санхүүжүүлэх хэрэгтэй.

Таамаглал 2 Эцэг эхийн хүүхэддээ зарцуулах цаг хомс байдаг нь санхүүгийн эрх чөлөөгүй байдалтай холбоотой гэсэн таамаглал хүүхдийнхээ хөгжилд оруулах хөрөнгө оруулалтад учирч буй хамгийн түгээмэл бэрхшээл нь санхүүгийн асуудал байдаг тул гэр бүлдээ зарцуулах цаг хомс байдаг нь судалгаанаас харагдаж байна. Цаашид ажил олгогчид шаардлагатай тохиолдолд ажилчдынхаа ажлын цагт уян хатан байх нь улс

орны ирээдүй болсон хүүхдийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах болно. (Дархан хотын засаг даргын захирамжийн жишээ)

Хүн төрөлхтөн хөгжлийн дээд шатанд хүрсэн үед ч хамгийн үнэ цэнэтэй баялаг бол үр хүүхэд, тэдний хэн болох нь хамгийн чухал асуудал байсаар байх болно.

Бага насны хүүхдийн хөгжлийн асуудлыг зөвхөн хэдэн цэцэрлэгийн барилга барихаар хязгаарлах бус, Монгол Улсын хөгжлийн үндэс нь хүний, ялангуяа бага насны хүүхдийн хөгжил гэдгийг хүн бүр ойлгож бага насны бүх хүүхдийнхээ хөгжилд чиглэсэн нийтийн хөрөнгө оруулалт хийх нь зүйтэй юм. Хүн төрөлхтөн хөгжлийн дээд шатанд хүрсэн үед ч хамгийн үнэ цэнэтэй баялаг бол үр хүүхэд, тэдний хэн болох нь хамгийн чухал асуудал байсаар байх болно.

Цаг үеэ олсон хөрөнгө оруулалт бизнест ашиг орлого авчирдаг бол үр хүүхдийнхээ ирээдүйд зориулан бүтээж буй үйлдэл бүр тань эцэг эх байхын үнэ цэнийг бий болгоно.

Энэ бүхнээс үзвэл эцэг эхийн хүүхдийнхээ ирээдүйд оруулж буй хөрөнгө оруулалтыг хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хүмүүжлийн анхдагч үед нь өгч чадвал гэр бүл төдийгүй улс орны эдийн засаг, хүний хөгжлийн тулгуурыг бий болгодог болох нь судалгаанаас харагдаж байна.

“Эцэг эхчүүд, бодлого боловсруулагч нарт хүргэх санал зөвлөмж”

- Эцэг эхчүүд хүүхдийнхээ насны онцлог, зан төлөвийн талаар мэдлэг мэдээлэлтэй байх

- Гэр бүлийн боловсролыг (Хэрхэн хүн байх, хүн бүтээх ухаан) шат дараатайгаар сургалтын системд оруулах, зохион байгуулах

- Ажлын ачаалалаас шалтгаалан ажил олгогчид ажилчиддаа цагийн уян хатан байдлыг бий болгох

- Эцэг эхчүүд бол хүүхдийнхээ ментор байх ёстой. Мэддэг чаддаг зүйлээ бусадтай хуваалцдаг, бусдаас суралцдаг байх

- Эцэг эхчүүд хүүхдээ хүмүүжлийн эерэг арга зүйгээр хүмүүжүүлдэг байх

- Хүүхдийн хамгийн чухал үед эхний 1000 хоног байдаг тул төрөөс ээжүүдэд олгогддог мөнгөн дүнг үе шаттайгаар нэмэгдүүлэх

- Эцэг эхчүүд өөрийн хүүхэд хүмүүжүүлэх ямар хэв загвартай гэдгээ мэддэг байх (О.Мягмар. Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд)

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Бага насны хүүхдийн цогц хөгжил. УБ 2020
2. Багш мэргэжлийн багц хөтөлбөрт хүмүүжлийн эерэг аргын үзэл санааг тусгах зөвлөмж. УБ 2009
3. Боловсролын хөгжил, судалгаа, арга, зүй., УБ.2018
4. О.Мягмар. Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд
5. Багшийн хөгжил мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын гарын авлага
6. Чадамжид суурилсан сургалтын гарын авлага., УБ.2013

---o0o---